

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ 2019-2023 он



Улаанбаатар хот 2024 он



Сонгинохайрхан дүүргийн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах үйлсэд Эрүүл мэндийн төвүүд, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Нэгдсэн эмнэлэг болон хувийн хэвшлийн эмнэлэгүүд ажиллаж байна. Жил ирэх тутам Сонгинохайрхан дүүрэгт оршин суугчдын тоо өсөн нэмэгдэж байгаа ба дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдээгээр 2023 онд эмнэлэгийн

ажиллагсдын тоо 354 байгаа бөгөөд энэ нь 2019 оноос 48(11.9%)-аар буурсан байна. 2023 оны байдлаар эмнэлэгийн нийт ажиллагсдын 24.6 хувь нь их эмч байгаа нь 2019 оноос 22 (20.2%)-оор буурсан байна.

Хүснэгт 1 . Эмнэлэгийн ажиллагсдын тоо

Он	2019	2020	2021	2022	2023	<u>2019</u> 2016%
Ажиллагсдын тоо-бүгд	402	359	366	352	354	104.9
Их эмчийн тоо	109	95	86	95	87	95.9
Эмнэлэгийн орны тоо	208	208	208	208	208	100.0
Нэг их эмчид ногдох хүний тоо	2 887	3 475	2 922	2 701.1	1 770.7	114.2

Мэдээллийн эх үүсвэр: Дүүргийн эрүүл мэндийн төвийн статистик мэдээ


Хүснэгт 2. Эмнэлэгийн тусгай мэргэжлийн ажилтны тоо

Он	Ажиллагсад- бүгд	Бага эмч	Эм найруулагч	Лаборант	Сувилагч	Рентгений техникч
2019	402	20	1	13	103	4
2020	359	17	1	11	94	4
2021	366	17	1	16	91	3
2022	352	10	2	12	88	4
2023	354	9	-	13	94	4
<u>2023</u> 2019%	88.1	45.0	0.0	-	91.3	-

Мэдээллийн эх үүсвэр: Дүүргийн эрүүл мэндийн төвийн статистик мэдээ

Дүүргийн хэмжээнд 2023 онд 6 342 эхээс 6 376 нярай төрсөн байгаа нь 2019 оноос 903 (12.5%) -аар төрсөн эх, нярайн тоо буурсан байна.

Зураг 1. Төрсөн эхийн тоо



2023 онд Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний тоо 2022 оноос 4792(4.2%)-аар , чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний тоо 15912(16.2%)-аар буурсан бол элэгний хорт хавдрын эрт илрүүлэгийн үзлэгт хамрагдсан хүний тоо 1 897 (13.6%)-аар өссөн байна.

2023 онд Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний тоо 2022 оноос 4792 (4.2%)-аар , чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний тоо 15912 (16.2%)-аар буурсан бол элэгний хорт хавдрын эрт илрүүлэгийн үзлэгт хамрагдсан хүний тоо 1 897 (13.6%)-аар өссөн байна. Мөн 2023 онд Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний 870(0.8%) нь оношлогдсон, Чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний 226(0.3%) нь, Элэгний хорт хавдрын эрт илрүүлэгийн үзлэгт хамрагдсан хүний 9(0.06%) нь хорт хавдараар тус тус оношлогдсон байна.

Хүснэгт 3. Амбулаторийн үзлэгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	<u>2023</u> 2022%
Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний тоо-бүгд	134 359	127 853	113 441	108 649	95.8
Эрэгтэй	59 532	53 341	47 387	41 720	88.0
Эмэгтэй	74 827	74 412	66 054	66 929	101.3
Давтан үзлэг	45 682	18 188	9 609	5 032	52.4
Оношлогдсон артерийн гипертензи	2 300	1 248	901	870	96.6
Чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний тоо-бүгд	110 047	103 268	98 032	82 120	83.8
Эрэгтэй	48 920	43 648	41 213	31 541	76.5
Эмэгтэй	61 127	59 620	56 819	50 579	89.0
Давтан үзлэг	29 995	8 334	4 461	2 275	51.0
Оношлогдсон чихрийн шижин	512	391	252	226	89.7
Элэгний хорт хавдрын эрт илрүүлэгийн үзлэгт хамрагдсан хүний тоо*	25 076	10 978	13 967	15 864	113.6
Эрэгтэй	10 287	4 594	5 512	5 975	108.4
Эмэгтэй	14 789	6 384	8 455	9 889	117.0
Давтан үзлэг	1 709	1 151	525	348	66.3
Оношлогдсон хорт хавдрын тоо	11	9	6	9	1.5 ¹

¹-дахин


Амбулаторийн үзлэгээр 2023 онд 93 321 халдварт бус өвчлөл бүртгэгдсэн нь 2022 оноос 36 882(28.3%)-аар буурсан бөгөөд нийт өвчлөлийн 57 940(62.1%) нь шинээр бүртгэгдсэн байна. 2023 онд нийт бүртгэгдсэн өвчлөлийн 84(0.1%) хорт хавдарын, 26(0.03%)осол гэмтлийн, 675(0.7%) томуу, томуу төст, 681(0.7%) нь 0-5 хүртэлх насны хүүхдийн халдварт бус суулгалт, 3 144(3.4%) 0-5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог халдварт өвчин байна.

Хүснэгт 4. Амбулаторын өвчлөлийн үзүүлэлт

Үзүүлэлт		2020	2021	2022	2023	2023 2022%
Амбулаторийн өвчлөл	Бүртгэгдсэн халдварт бус өвчлөл-Бүгд	46 692	56 313	130 203	93 321	71.7
	Шинэ	27 188	24 690	56 764	57 940	102.1
	Хуучин	19 504	31 623	73439	40 309	54.9
	Хорт хавдрын өвчлөл	154	63	56	84	150.0
	Осол гэмтлийн өвчлөл	59	15	10	26	2.6 ¹
	Томуу, томуу төст өвчин (J09-J11)	273	603	1 071	675	63.0
	0-5 хүртэлх насны хүүхдийн халдварт бус суулгалт өвчин (K52.0-K52.9)	121	59	97	681	7 ¹
	0-5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог халдварт өвчин (J00-J06, J20-J22)	698	1 172	1 786	3 144	176.0
	0-5 хүртэлх насны жинлэсэн хүүхдийн тоо	152 443	143 878	146 138	113 628	77.6
	Туранхай /жин, өндрийн үзүүлэлт/	720	312	352	257	73.0
	Тураалтай /жин, насны үзүүлэлт/	465	199	229	189	82.5
	Өсөлтийн хоцрогдолтой /өндөр, насны үзүүлэлт/	599	270	276	324	117.4
	А амин дэм уусан	36 542	20 413	27 149	14 619	53.9
	Д амин дэм уусан	60 116	74 899	66 575	56 312	84.6
	Олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн	-	100	358	3 450	9.6 ¹

¹-дахин

Зураг 2. Бүртгэгдсэн халдварт бус өвчлөлийн тоо



Жирэмсний хяналтад шинээр орсон эхчүүдийн тоо 2023 онд 12 457 байгаа нь 2022 оноос 13 293 (51.7%) -аар буурсан байна. Шинээр хяналтад орсон эхчүүдийн 1 839(93.5%) нь жирэмсний эхний 3 сартайд хяналтад орсон байна. 2023 онд шинээр хяналтад орсон жирэмсэн эхчүүдийн 160(8.1%) нь цус багадаалттай, 22 (1.1%) нь трихомониаз өвчтэй, 2(0.1%) нь заг хүйтэн өвчтэй, 23 (1.2%) тэмбүү өвчтэй гарсан байна.

Хүснэгт 5. Жирэмсэн эхчүүдийн хяналтын үзлэгийн үзүүлэлт

Үзүүлэлт		2020	2021	2022	2023	<u>2023</u> 2022%	
Жирэмсний хяналт	Жирэмсний хяналтад байгаа эмэгтэйчүүдийн тоо	3 945	31 254	25 750	12 457	48.3	
	Жирэмсний хяналтанд шинээр авсан эмэгтэйчүүдийн тоо	7 821	4 739	4 120	1 967	47.7	
	Эхний 3 сартайд	4-6 сартайд	7 012	4 221	3 787	1 839	48.6
		7 ба түүнээс дээш сартайд	748	490	310	117	37.7
		7 ба түүнээс дээш сартайд	61	28	23	11	47.8
	Жирэмсний хяналтад шинээр авсан эмэгтэйчүүд цусны шинжилгээнд хамрагдсан тоо	7 821	4 739	4 120	1 967	47.7	
	Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо	347	192	231	160	69.3	
Шинээр хяналтанд хамрагдсан жирэмсний эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээ	Трихомониаз илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо	7 821	4 739	4 120	1 967	47.7	
	үүнээс: эерэг	63	56	36	22	61.1	
	Заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо	7 821	4 739	4 120	1 967	47.7	
	үүнээс: эерэг	42	7	9	2	22.2	
	Тэмбүү илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо	7 821	4 704	4 120	1 967	47.7	
	үүнээс: эерэг	209	102	84	23	27.4	
	ХДХВ/ДІХ илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо	7 821	4 704	4 120	1 967	47.7	

2023 онд нийт 2 560 халдварт өвчин гарсан нь 2022 оноос 18 803 (8.3дахин) цөөн байна. Covid-19 өвчин 2023 онд огт бүртгэгдээгүй нь халдварт өвчин өмнөх оноос эрс буурсан гол шалтгаан болж байна. 2023 онд гарсан нийт халдварт өвчний 56.1 хувь нь цочмог халдварт өвчин байна. Нийт халдварт өвчний 612(23.9%) нь салхин цэцэг өвчин бөгөөд 2022 оноос 3.8 дахин нэмэгдсэн байна. Цусан суулга 376(14.7%) гарсан нь 2022 оноос 46(13.9%)-өөр нэмэгдсэн байна. Харин Менингит (2), бруцеллөз, А84 хачигаар дамжих вируст энцефалит(1), ба А09 халдварын гаралтай гастроэнтерит ба суулга өвчин(3) нь 2022 онд огт бүртгэгдээгүй боловч 2023 онд бүртгэгдсэн байна.

2023 онд тэмбүү өвчний 365(14.3%) тохиолдол бүртгэгдсэн нь 2022 оноос 142(63.7%)-аар, заг хүйтэн өвчин 2023 онд 183(7.2%) бүртгэгдсэн нь 2022 оноос 76(71.0%)-аар, трихомониаз өвчин 2023 онд 215(8.4%) бүртгэгдсэн нь 2022 оноос 93(2.1 дахин), шинээр илэрсэн сүрьеэ өвчин 2023 онд 343(13.4%) бүртгэгдсэн нь 2022 оноос 14(4.3%)-аар тус тус өссөн байна.

Хүснэгт 10. Халдварт өвчний гаралтын тоо, төрлөөр

Үзүүлэлтүүд	2020		2021		2022		2023		2023 2022%
	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	
Бүгд халдварт өвчин	3 080	94.6	26 164	803.38	21 363	630.9	2 560	74.9	11.2
Үүнээс: цочмог халдварт өвчин	1 209	37.1	25 284	776.36	20 611	608.7	1 436	42.0	7.0
Цусан суулга	564	17.3	102	3.13	330	9.7	376	11.0	113.9
Улаан эсэргэнэ	39	1.2	3	0.09	8	0.2	135	3.9	16.9 ¹
Менингит	1	0.03	-	-	-	-	2	0.1	2 ¹
Нярайн халдвар	2	0.06	-	-	-	-	-	-	-
Гепатит	36	1.11	10	0.31	28	0.8	18	0.5	64.3
Салхинцэцэг	258	7.92	11	0.34	160	4.7	612	17.9	3.8 ¹
Гахайн хавдар	8	0.25	1	0.03	1	0.0	8	0.2	8 ¹
Сальмонеллэз	46	1.41	4	0.12	25	0.7	22	0.6	88.0
Бруцеллэз	-	-	-	-	-	-	1	0.0	1 ¹
Ёлом	18	0.55	1	0.03	1	0.0	12	0.4	12 ¹
ГХА өвчин	150	4.6	-	-	128	3.8	235	6.9	183.6
Хачигт рикеттикоз	4	0.12	-	-	-	-	-	-	-
Хоолны хордлого	9	0.2	-	-	1	0.0	11	0.3	11 ¹
Спирохетээр сэдээгдсэн халдвар а69	2	0.06	-	-	-	-	-	-	-
Covid-19	71	2.18	25 150	772.24	19 924	588.4	-	-	-
В34.1 Эннтеровируст халдвар тодорхойгүй	133	4.08	-	-	-	-	-	-	-
A84. Хачигаар дамжих вируст энцефалит	1	0.03	-	-	-	-	1	0.0	1 ¹
A09 Халдварын гаралтай гастроэнтерит ба суулга өвчин	-	-	-	-	-	-	3	0.1	3 ¹
Тэмбүү	618	18.98	289	8.87	223	6.6	365	10.7	163.7
Заг хүйтэн	444	13.63	118	3.62	107	3.2	183	5.3	171.0
Шинэ илэрсэн сүрьеэ	510	15.66	353	10.84	329	9.7	343	10.0	104.3
Мөөгөнцөр	-	-	-	-	-	-	19	0.6	19 ¹
Трихоминиаз	162	4.97	115	3.53	93	2.7	215	6.3	2.3 ¹
Төрөлхийн тэмбүү	5	0.15	-	-	-	-	-	-	-

¹дахин

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



ХЯНАСАН:

Б.Баатарцогт Сонгинохайрхан дүүргийн
Статистикийн хэлтсийн дарга

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

С.Удвал Сонгинохайрхан дүүргийн
Статистикийн хэлтсийн мэргэжилтэн